

2024.05.29

Цахим орчин дахь залилах гэмт хэргийг бууруулах олон улсын сайн туршлага

Удирдагч багш: Б. Одонтунгалаг (Sc.D)

Б. Номундарь
М. Тэргэл



АГУУЛГА

01

Удиртгал

02



Үндсэн хэсэг

03

Дүгнэлт, санал

04

Ном зүй



1.УДИРТГАЛ

УДИРТГАЛ

Lorem ipsum dolor sit amet, consectetur adipiscing elit. Donec vulputate nulla ac ante, rhoncus vel efficitur felis. Cras fermentum Praesent odio odio.



Цахим технологийн хөгжил нь иргэдэд олон давуу талыг дагуулж ирсэн ч гэмт хэргийн шинэ хэлбэрүүдийг бий болгосон. Тэдгээрийн нэг нь цахим орчин дахь залилах гэмт хэрэг юм. Энэхүү бүтээлд цахим орчин дахь залилах гэмт хэргийн түүхэн уламжлал, эрх зүйн зохицуулалт, бүрэлдэхүүний онцлог, олон улсын сайн туршлагыг судлан Монгол Улсад хэрэгжүүлэх боломжит арга замыг танилцуулна.



СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Судалгааны зорилго:

Цахим хэрэгсэл ашиглан залилах гэмт хэргийн түүний уламжлал шинэчлэл, олон улсын сайн туршлагыг судалж Монгол Улс дахь эрүүгийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход оновчтой санал дэвшүүлэхэд оршино.

Энэхүү зорилгод хүрэхийн тулд:

- (1) цахим гэмт хэрэгсэл ашиглаж үйлдсэн залилах гэмт хэргийн түүхэн уламжлал, шинэчлэл,
- (2) цахим хэрэгсэл ашиглаж залилах гэмт хэргийн бүрэлдэхүүн, зүйлчлэлийг судлах,
- (3) цахим хэрэгсэл ашиглаж үйлдсэн гэмт хэргийн практик судалгааг хийх,
- (4) олон улсын гэрээ, конвенцийг судлах,
- (5) гадаад орнуудын цахим хэрэгсэл ашиглаж залилах гэмт хэргийн зохицуулалт, сайн туршлагыг судлах,
- (6) Монгол Улс дахь цахим хэрэгсэл ашиглаж залилах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход оновчтой санал, шийдэл дэвшүүлэх, дүгнэлт үйлдэх зэрэг зорилтуудыг дэвшүүлсэн болно.

2. ҮНДСЭН ХЭСЭГ

ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ

1926-1942
он

Эрүүгийн анхны төрөлжсөн хууль болох "Шүүх цаазын бичиг"-т **"Ашгийг хичээж залилан мэхэлж бусдын эрхийг эдлэх буюу эсхүл эд юмыг ашиглан шингээвээс"** гэж заасан.

**Залилах гэмт
хэрэг**

1942-
2002 он

Эрүүгийн хууль тогтоомжид залилах гэмт хэргийн тодорхойлолт, бүрэлдэхүүн, ангилал, ял шийтгэл нь үе үе өөрчлөгдөн хөгжиж ирсэн.

2015 он

Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйлд **"цахим хэрэгсэл ашиглан залилах"** гэх үйлдлийн аргыг тусгайлан хуульчилсан.

ЗАЛИЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ (ЭХТА 17.3)

Үндсэн бүрэлдэхүүн

“Хуурч, эсхүл баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглаж, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох, сүсэг бишрэлийг далимдуулах, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж, эсхүл нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглаж эзэмшигч, өмчлөгчийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авсан бол” гэж заасан.

Хүндрүүлэх бүрэлдэхүүн

Энэ гэмт хэргийг албан тушаалын байдлаа ашиглаж, бусдад ноцтой, эсхүл их хэмжээний хохирол учруулж үйлдсэн, байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон, зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол хүндрүүлэх шинжид тооцно.

Цахим орчинд дахь залилах гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж

Объект

Бусдын өмчлөх эрх

Объектив тал

Е-mail, мессеж бичиж илгээх, интернэт худалдаа хийх нэрээр өөр компани, хүний нэрийн өмнөөс харилцаж, өөрийн данс руу мөнгө шилжүүлэн авах, эзнийг хуурч авсан банкны карт, пин кодыг ашиглан АТМ-ээс мөнгийг авах г.м

Субъект

Хэн болох нь тодорхойгүй, ихэвчлэн нууц нэр, эсхүл нэргүй этгээд

Субъектив тал

Гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгдэнэ.


Олон улсын гэрээ, конвенц

Будапештын конвенц

- 2001 онд батлагдсан "Цахим гэмт хэргийн тухай Будапештын конвенц" нь цахим орчинд үйлдэгдэх гэмт хэргийг таслан зогсоох, илрүүлэх, мөрдөн шалгах, яллах, урьдчилан сэргийлэх зорилготой.

НҮБ-ын конвенц

- Мэдээлэл, харилцаа холбооны технологийг гэмт хэргийн зорилгоор ашиглахтай тэмцэх тухай НҮБ-ын Конвенц нь 2024 онд батлагдахаар төлөвлөгдөж байна.




Гадаад орнуудын туршлага




- Цахим орчин дахь залилах гэмт хэргийг "Компьютерийн залилан" гэж тусгайлан хуульчилсан.



- Цахим орчин дахь залилах гэмт хэргийг "компьютер зэргийг ашиглан залилах" гэж тусад нь хуульчилсан.




- Цахим орчин дахь залилах гэмт хэргийг "цахим төлбөрийн хэрэгсэл ашиглаж залилах", "компьютерийн мэдээллийн салбарт залилан хийх" гэж ангилан хуульчилсан



- Цахим орчин дахь залилах гэмт хэргийг мөрдөн шалгах, урьдчилан сэргийлэх ажиллагааг тусгай нэгж хариуцдаг.

Цахим орчинд үйлдэгдэж буй залилах гэмт хэргийн практик судалгаа

- ФАТФ-ийн 40 зөвлөмжид “Мөнгө угаах гэмт хэрэгт бүх хүнд гэмт хэргийг түүний дотор өргөн хүрээний суурь гэмт хэргийг тооцно” гэжээ.
- 2020-2023 оны хугацаанд буюу сүүлийн 4 жилийн дунджаар нийт мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийн 8.2 хувийг “Залилах” гэмт хэрэг эзэлж байна.
- Эзэн холбогдогч нь тогтоогдоогүй залилах гэмт хэрэг 2010 онд 65, 2011 онд 69, 2012 онд 136, 2013 онд 68, 2014 онд 196, 2015 онд 224, 2016 онд 305, 2017 онд 1980, 2018 онд 3972, 2019 онд 2963 болж өссөн бөгөөд үүн дотор цахим орчинд үйлдэгдэж буй залилах гэмт хэрэг 2015 онд 17, 2016 онд 69, 2018 онд 590, 2019 онд 641, 2023 онд 7905 болж өссөн.



Шүүхийн шийдвэрт хийсэн судалгаа

Үйлдлийн арга
Гэмт этгээд өөрийгөө гэр бүл, найз нөхөд гэж итгүүлэх
Хуурамч зар байршуулж мөнгө авах
Сургууль, ажил гэх мэт зохиомол мэдээлэл өгөх
Онлайн шоп ажиллуулж урьдчилгаа авах
Зуслангийн эрх, тасалбар зарна гэх мэт
Санхүү авна гэсэн хуурамч зар
Бусад

- Практикт үйлдэгдэж буй нийт залилах гэмт хэргийн үйлдлийн аргыг мэдэх нь тус гэмт хэргийн эсрэг авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлоход ихээхэн ач холбогдолтой тул shuukh.mn сайтад оруулсан сүүлийн 3 сарын хугацаанд Эрүүгийн хэргийн АШШ-ээр шийдвэрлэгдсэн 96 гэмт хэргийг судалсан.
- Оногдуулж буй ялын тухайд, шүүхээс 2018-2020 оны эхний хагас жилд залилах гэмт хэргийг шийдвэрлэхдээ

56 хувьд нь торгох,

15 хувь нь нийтэд тустай ажил хийлгэх,


12 хувьд нь хорих ял тус тус оногдуулж,

16 хувьд нь хорих ял оногдуулахгүйгээр тэнсэн,

2 хувийг нь эрүүгийн хариуцлагаас чөлөөлсөн нь ялын үр нөлөө хангалтгүй байна гэж дүгнэхэд хүргэсэн.

Хохирогчдын насны тухайд

Залилах гэмт хэргийн хохирогчдын насны тухайд авч үзвэл, 2010-2019 оны хооронд хохирсон иргэдийн 27.1 хувь нь 18-29 насны, 32.1 хувь нь 30-39 насны, 23 хувь нь 40-49 насны, 11 хувь нь 50-59 насны, 4.5 хувь нь 60 аас дээш насныхан байна.



3. ДҮГНЭЛТ, САНАЛ

ДҮГНЭЛТ

- Цахим хэрэгсэл ашиглаж үйлдсэн гэмт хэргийг залилах гэмт хэргээс тусдаа бие даасан гэмт хэрэг болгон хуульчилснаар манай улсад олон улсын гэрээ конвенцийг ашиглах боломжийг бүрдүүлэх, оновчтой ял оноох, тус гэмт хэргийн гаралтыг багасгах, гэмт этгээд үйлдлээ давтан хийх, илүү мэргэших боломжийг хумих зэрэг олон давуу талтай.
- Мөн Монгол улс SEON-ны хийсэн судалгаагаар цахим аюулгүй байдал хамгийн сул 10 улсын тоонд багтсан. Энэ нь Монгол Улс цахим орчин дахь залилах гэмт хэргийн талаарх зохицуулалт хангалттай бус гэдгийн нэг илрэл. Түүнчлэн, тус гэмт хэргийн хохирогчдын хувьд ихэвчлэн 18-49 насныхан байх бөгөөд энэ анги цахим хэрэгсэл хамгийн их ашигладаг хэдий ч цахим орчинд залилах гэмт хэргийн тухайд мэдлэг мэдээлэл дутуу, нөгөө талаас тус гэмт хэргийг таниулах компанит ажил, сургалт, таниулах ажиллагаа манай улсад маш дутмаг байдагтай холбоотой. Тиймээс юуны түрүүнд манай улс иргэдэд тус гэмт хэргийг таниулах сурталчлах зорилгоор компанит ажил авч хэрэгжүүлэх, нөгөө талаар цахим залилантай тэмцэх тусгай алба байгуулах шаардлагатай байна.

САНАЛ

1. Эрүүгийн хуулийг боловсронгуй болгох

- Цахим орчин дахь залилах гэмт хэргийг тусгайлан хуульчлах, ялын бодлогыг сайжруулах.

2. Олон нийтийн мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх

- Иргэдэд цахим орчны аюулгүй байдал, залилангаас урьдчилан сэргийлэх талаар сургалт, мэдээлэл түгээх.

3. Тусгай алба байгуулах, дэвшилтэт техник, технологи ашиглах

- Цахим орчин дахь залилах гэмт хэргийг мөрдөн шалгах, илрүүлэх, урьдчилан сэргийлэх чиг үүрэгтэй тусгай алба байгуулах.
- Залилангийн шинж чанарыг автоматаар илрүүлэх машины сургалтын техникүүд нь сэжигтэй хэв маягийг сурч дараа нь таних боломжтой мэдрэмжийн сүлжээ бий болгох зэрэг байдлаар тэмцэх.

4. НОМ ЗҮЙ

НОМ ЗҮЙ

1. Монгол улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал. УБ, 2011.
2. С.Нарангэрэл нар. Монгол улсын Эрүүгийн эрх зүй: Үзэл баримтлал, уламжлал, сургамж-нэгэн сэдэвт бүтээл. УБ, 2019.
3. БНМАУ-ын Эрүүгийн эрх зүй-Тусгай анги. УБ, 1979.
4. БНМАУ-ын Эрүүгийн хуулийн дэлгэрэнгүй тайлбар. УБ, 1989.
5. МУ-ын Дээд Шүүхийн мэдээлэл №3. УБ, 1997.
6. Г.Совд. Монгол улсын эрүүгийн хуулийн тайлбар. УБ, 2002.
7. Б.Энхболд. Эрүүгийн эрх зүй тусгай анги. УБ, 2018.
8. Т.Золбоо. Гэмт хэргийн бүрэлдүүн. УБ, 2023.
9. Х.Доржпалам. Монгол Улсын эрүүгийн эрх зүй-тусгай анги. УБ, 2021.
10. Ж. Эрдэнэбулган нар. Монгол, Орос, Хятад, Герман улсын эрүүгийн хууль. УБ, 2021.
11. С.Учрал. Залилах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн зохицуулалт, зүйлчлэлийн асуудал /Бакалаврын судалгааны ажил/. УБ, 2022.



**АНХААРЛ
ХАНДУУЛСАНД
БАЯРЛАЛАА.**